

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ДОТООД АУДИТ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2024.06.10

Нийгмийн даатгалын газрын даргын баталсан “Дотоод аудитын төлөвлөгөө”-ний хүрээнд нийгмийн даатгалын сан болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан байдал, хөтлөлт, баримт бичгийг бүрэн оруулсан эсэхэд дотоод аудит хийлээ.

Шалгалтын явцад хийгдсэн ажил, шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээ, мэдээллийг байршуулсан тоон мэдээллийг хүснэгтээр харуулбал:

2024 оны 5 дугаар сарын байдлаар						
Тайлангийн төрөл	Мэдээллэх тоо	Мэдээллэсэн тоо		Мэдээллээгүй тоо	Хэрэгжилт	
		Хугацаандаа	Хоцорсон		Нийт	Хугацаандаа
Сан	68	52	0	16	76%	76%
Үйл ажиллагаа	73	54	4	15	79%	74%
Нийт дүн	141	106	4	31	78%	75%

Нийгмийн даатгалын сан: 2024 оны 5 дугаар сарын байдлаар нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 68 мэдээлэл байршуулахаас 52 мэдээллийг хугацаандаа, 16 мэдээллийг мэдээллээгүй, хэрэгжилт 76 хувь, хугацаандаа байршуулсан 76 хувь байна.

Үүнээс хугацаандаа оруулсан 52 мэдээллээс мэдээллийг хугацаандаа-19, оруулах мэдээлэл байхгүй-33, мэдээлэл оруулаагүй-16 зэрэг тоон үзүүлэлттэй шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллажээ.

Үйл ажиллагаа: 2024 оны 5 дугаар сарын байдлаар байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 73 мэдээлэл байршуулахаас 4 мэдээллийг хугацаа хоцроож, 54 мэдээллийг хугацаандаа, 15 мэдээллийг мэдээллээгүй, хэрэгжилт 79 хувь, хугацаандаа байршуулсан 74 хувь байна.

Үүнээс хугацаандаа оруулсан 54 мэдээллээс мэдээллийг хугацаандаа-19, оруулах мэдээлэл байхгүй-35, хугацаа хоцроосон-4 зэрэг тоон үзүүлэлттэй шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллажээ.

Газрын үйл ажиллагааны зардалтай холбоотой (нэг удаагийн тэтгэмж, төрийн албан хаагчдын 6 сарын цалинтэй тэнцэх мөнгөн урамшуулал, эх үрсийн баяр, тэмцээн) гаргасан 151,782,253 сая төгрөгийн мөнгөн дүнтэй 5 тушаалыг цахим хуудсанд бүрэн байршуулж ажилласан байна.

Нийгмийн даатгалын сан болон үйл ажиллагааны зардлын гүйцэтгэлтэй холбоотой мэдээ, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 78 хувьтай байршуулснаас хугацаандаа 75 хувьтай байршуулж ажиллажээ.

Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, санал, дүгнэлт:

- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах
- Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, давтан гаргахгүй байх
- НДЕГазрын чиглэл, Аудитын байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах

Иймд цаашид “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллах, мэдээ, мэдээлэл, мэдэгдэл, гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэрүүдийг тухай бүр байршуулж ажиллахыг холбогдох албан тушаалтнуудад зөвлөмж өгч ажиллав.

АУДИТ ХИЙСЭН:

Т.ЧИНЗОРИГ /ХШДАТАСГИЙН ДАРГА/